



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.51 дэх заалтад “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв гэж Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу бүрдүүлж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасан

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ны чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль тогтоомжийг хүчингүй болгосонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсан. Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд урсгал зардлыг бууруулах зохицуулалт хийхтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн орлого буурахаар байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авсантай холбогдуулан Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа-2025” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, хүrtээмжийг сайжруулах, даатгуулагчийг өвчлөхөөс өмнө урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулах зорилтыг хангах хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын төсвийг гүйцэтгэлд суурилсан хэлбэрээр санхүүжүүлэх шинэчлэлийн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төслийг салбарын гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийг үргэлжлүүлж, эмнэлгийн тусlamж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байхаар боловсруулав.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу 2025 оны төсвийн жилд эрүүл мэндийн даатгалын сан бие даасан хэлбэрээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---